Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын үйл ажиллагааны гол зорилгоо “Монгол улсын үндсэн хууль, бусад хууль аймаг сумын удирдлагын бодлогыг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан төр иргэний харилцааг ил тод нээлттэй болгож, иргэд олон нийтийн санал санаачилгад тулгуурлан төрийн бодлогыг шударгаар хэрэгжүүлэн үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэхэд манай хамт олны эрхэм зорилго оршино.

Төрийн албаны нэгдмэл байдлыг хангаж төрийн бодлого шийдвэрийг иргэдэд шуурхай үзүүлж, төрийн бодлого шийдвэрийг цаг алдалгүй хэрэгжүүлэх” чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль мөрдөгдөж байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдаж, түүнтэй холбогдон гарсан Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын заавар, журмууд батлагдсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ. Санхүү, төрийн сангийн хэлтэс болон санхүү хяналт аудитын алба санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийдэг байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь нийтлэг мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгон холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн бүртгэл хөтөлдөг бөгөөд өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримттай болох шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,747.4 сая төгрөгөөр буюу 64 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Мөнгөн хөрөнгө	287.7	197.7	(90.0)
Авлага	201.4	150.3	(51.1)
Бараа материал	210.1	58.9	(151.2)
Үндсэн хөрөнгө	3,601.1	1,133.6	(2,467.6)
Нийт хөрөнгийн дүн	4,301.6	1,551.1	(2,750.5)
Богино хугацаат өр төлбөр	26.2	35.5	9.3
Засгийн газрын хувь оролцоо	4,275.4	1,515.6	(2,759.8)
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,301.6	1,551.1	(2,750.5)

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын /Төсвийн төвлөрүүлэн захирагч/ 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө 90.0 сая, авлага 51.1 сая, бараа материал 151.2 сая, үндсэн хөрөнгө 2,467.6 сая төгрөгөөр тус тус буурсан байна. Нийт өр төлбөр 9.3 сая төгрөгөөр өссөн ба Асгат сумын Засаг даргын өмч 2,759.8 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь бүтцийн өөрчлөлтөөр Соёлын төвийн 231.9 сая, сургуулийн 1,829.4 сая, цэцэрлэгийн 490.7 сая, эмнэлгийн 539.9 сая төгрөгийн хөрөнгийг тус тус дээд шатны төсвийн захирагчид шилжүүлсэнтэй холбоотой бууралт байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 197.7 сая төгрөг болж, өмнөх оноос 90.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банкинд байгаа бэлэн мөнгө	287.7	197.7	(90.0)
Төгрөг	287.7	197.7	(90.0)
Төрийн сангийн харилцах	286.1	197.4	(88.7)
Арилжааны банк дахь харилцах	0.8	0.3	(0.4)
Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.9	-	(0.9)

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын /Төсвийн төвлөрүүлэн захирагч/ 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 197.7 сая төгрөгийн 113.2 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд, Эргэлтийн эмийн сангийн арилжааны банкинд дахь дансны үлдэгдэл 0.3 сая төгрөг, орон нутаг хөгжүүлэх сангийн харилцах дансны үлдэгдэл 38.8 сая төгрөг, сум хөгжүүлэх сангийн харилцах дансны үлдэгдэл 45.4 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт

- Уул уурхайн хариуцлагын гэрээгээр төвлөрсөн 18.0 сая төгрөгийн хандивын орлогыг ИТХ-аар батлуулалгүй нэмэлтийн дансанд авч зарцуулсан. /Асгат ЗДТГ/
- Сахилгын шийтгэл хүлээсэн албан хаагчдад үр дүнгийн урамшуулал 1.3 сая төгрөг олгосон. /Асгат ЗДТГ/
- Орон нутгийн хөгжлийн сангаас зориулалтын бус 0.9 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлж, үргүй зардал гаргасан байна. /Орон нутгийн хөгжлийн сан/

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 150.3 сая төгрөг болж, өмнөх оноос 51.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.6	-	(0.6)
Төлбөртэй үйлчилгээний авлага	59.7	-	(59.7)
Татаас, санхүүжилтийн авлага	-	0.8	0.8
Бусад авлага	141.1	149.5	8.4
Байгууллагаас авах авлага	42.9	-	(42.9)
Хувь хүмүүсээс авах авлага	98.2	149.5	51.3
Авлагын дүн	201.4	150.3	(51.1)

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын /Төсвийн төвлөрүүлэн захирагч/ 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сангийн төвлөрүүлэх авлага 0.06 сая, ажиллагсдаас авах авлага 0.6 сая, төлбөртэй үйлчилгээний авлага 59.7 сая төгрөгөөр буурсан нь дансны авлага 51.1 сая төгрөгөөр буурахад нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт

- Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлагаас хугацаа хэтэрсэн 28.3 сая төгрөгийн үлдэгдэл байна.
- Мөн хүүгийн болон үндсэн зээлийн авлагыг гэрээнд заасан хугацаанд 18.6 сая төгрөг төвлөрүүлээгүй байна. /Хоршоо хөгжүүлэх сан/

3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 58.9 сая төгрөг болж, өмнөх оноос 141.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
БАРАА МАТЕРИАЛ	210.1	58.9	(151.2)
Түүхий эд материал	44.7	28.6	(16.2)
Тусгай зориулалттай материал	9.5	-	(9.5)
Эм боох материал	35.2	28.6	(6.7)
Хангамжийн материал	145.5	23.9	(121.7)
Бичиг хэргийн материал	5.3	0.4	(5.0)
Аж ахуйн материал	36.4	20.7	(15.7)
Түлш, шатах тослох материал	6.3	0.3	(6.0)
Барилгын засварын материал	0.3	-	(0.3)
Хүнсний материал	5.0	-	(5.0)
Бусад хангамжийн материал	92.2	2.5	(89.7)
Мал амьтад	19.9	6.5	(13.4)
НӨӨЦИЙН БАРАА	1.2	10.7	9.4
Тэжээлийн нөөц	-	10.0	10.0
Бусад нөөц	1.2	0.7	(0.6)

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын /Төсвийн төвлөрүүлэн захирагч/ 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт бараа материал 72 хувиар буурсан ба бараа материалын 41 хувийг түүхий эд материал, 34 хувийг хангамжийн материал, нөөцийн бараа 15 хувь, мал амьтад 9 хувийг эзэлж байна.

Бараа материалын үлдэгдлийг байгууллагаар нь задалж үзвэл Засаг даргын тамгын газар 26.7 сая төгрөгийн бараа материал болон 10.0 сая төгрөгийн тэжээлийн нөөцийн үлдэгдэлтэй, Иргэдийн төлөөлөгчдийн хурал 5.5 сая төгрөгийн бараа материал ба 0.7 сая төгрөгийн тэжээлийн нөөцийн үлдэгдэлтэй, Эмийн эргэлтийн сан 26.7 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,133.6 сая төгрөг болж, өмнөх оноос 2,467.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,601.1	1,133.6	(2,467.6)
Биет хөрөнгө	3,539.3	1,034.1	(2,505.2)
Барилга, байгууламж, орон сууц	3,341.3	718.8	(2,622.5)
Хуримтлагдсан элэгдэл	278.9	138.4	(140.5)
Авто-тээврийн хэрэгсэл	270.5	276.8	6.3
Хуримтлагдсан элэгдэл	229.3	187.3	(42.1)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	470.8	136.7	(334.1)
Хуримтлагдсан элэгдэл	289.3	51.8	(237.5)
Тавилга, аж ахуйн эд хогшил	271.0	68.4	(202.6)
Хуримтлагдсан элэгдэл	218.5	29.9	(188.6)
Бусад үндсэн хөрөнгө	343.7	335.4	(8.3)
Хуримтлагдсан элэгдэл	168.8	94.8	(74.0)
Ном	26.8	0.2	(26.6)
Биет бус хөрөнгө	61.9	99.5	37.7
Програм хангамж	3.8	5.5	1.7
Хуримтлагдсан элэгдэл	2.6	0.4	(2.2)
Бусад биет бус хөрөнгө	61.2	94.4	33.2
Хуримтлагдсан элэгдэл	0.6	-	(0.6)

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын /Төсвийн төвлөрүүлэн захирагч/ 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засаг даргын тамгын газар 1,113.1 сая төгрөг, Иргэдийн төлөөлөгчдийн хурал 15.4 сая төгрөг, Асгат Улаан Дэл ОНӨҮГ 2.9 сая төгрөг, Эмийн эргэлтийн сан 2.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Нийт үндсэн хөрөнгийн 91 хувийг буюу 1,034.1 сая төгрөгийн хөрөнгө нь биет хөрөнгө, 9 хувь буюу 99.5 сая төгрөгийн хөрөнгө нь биет бус хөрөнгө байна.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 35.5 сая төгрөг болж, өмнөх оноос 9.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөр	26.2	35.5	9.3
Ажилчидтай холбогдсон өглөг	0.8	-	(0.8)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.1	-	(0.1)
Бусад өглөг	25.3	35.5	10.2
Байгууллагад төлөх өглөг	21.9	33.1	11.2
Хувь хүмүүст төлөх өглөг	-	0.9	0.9
Татварын өглөг /ТӨҮГ/	3.4	1.5	(1.9)

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын /Төсвийн төвлөрүүлэн захирагч/ 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сангийн 0.8 сая, Засаг даргын тамгын газрын 0.9 сая, Эмийн эргэлтийн сангийн өглөгийн үлдэгдэл 1.5 сая, орон нутгийн хөгжлийн сангийн өглөгийн үлдэгдэл 32.0 сая төгрөг байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,518.8 сая төгрөг болж, өмнөх оноос 2,756.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,275.4	1,515.6	(2,759.8)
Засгийн газрын хувь оролцоо	4,275.4	1,515.6	(2,759.8)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,142.4	269.5	(872.9)
- хувийн	0.8	5.9	5.1
Хуримтлагдсан үр дүн	2,769.9	1,060.7	(1,709.2)
Өмнөх үеийн үр дүн	2,509.2	3,718.7	1,209.4
Тайлант үеийн үр дүн	260.6	(2,658.0)	(2,918.6)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	362.3	179.5	(182.8)

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын /Төсвийн төвлөрүүлэн захирагч/ 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 1,060.7 сая төгрөг болж, тайлант үеийн 2,658.0 сая төгрөгийн үр дүнгийн бууралт, 2021 оны хуримтлагдсан үр дүнгийн 1,209.4 сая төгрөгийн өсөлтийн үр нөлөөгөөр нийт 1,709.2 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Бүтцийн өөрчлөлт хийж хөрөнгө шилжүүлсэнтэй холбогдуулан Засгийн газрын оруулсан капитал 872.9 сая төгрөгөөр буурсан, Эмийн эргэлтийн сангийн өөрийн өмч 5.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5.11 Орлогын данс

Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын 2022 оны татварын орлого 195.0 сая, бусад татвар хураамж 116.7 сая, татварын бус орлого 3.8 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 547.2 сая, ТӨҮГ-ын орлого 29.7 сая, ОНХС-ийн орлого 249.5 сая, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан

хөрөнгийн орлого 9.6 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 24.7 сая, орон нутгийн төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилтэд 898.9 сая, аймгийн төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилтэд 370.5 сая, төвлөрүүлэх шилжүүлэг 12.0 сая, бусад орлого 2.6 сая нийт 2,460.2 сая төгрөгийн санхүүжилт, санхүүгийн дэмжлэг болон татварын болон татварын бус орлого төвлөрсөн байна. Энэ нь өмнөх оны орлогоос 741.5 сая төгрөгөөр буюу 23 хувиар буурсан үзүүлэлт байна.

Сумын татварын орлого 254.3 сая төгрөг байхаар төлөвлөж, гүйцэтгэлээр 23 хувиар давж 311.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 10. Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт орлого ба тусламжийн дүн	523.6	318.3	(205.3)	61%
Татварын орлого	254.3	311.7	57.4	123%
Орлогын албан татвар	112.0	145.6	33.6	130%
Хувь хүний орлогын албан татвар	112.0	145.6	33.6	130%
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилгах хөдөлмөр эрх	80.0	107.2	27.2	134%
Үйл ажиллагааны орлого	2.0	9.1	7.1	457%
Хөрөнгийн орлого	28.0	19.5	(8.5)	70%
Хөрөнгө борлуулсны орлого	2.0	4.5	2.5	226%
Шууд бус орлого	-	5.2	5.2	-
Хөрөнгийн албан татвар	83.3	49.4	(33.9)	59%
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	1.8	-	(1.8)	-
Бууны албан татвар	1.5	0.7	(0.8)	48%
Малд ногдуулах албан татвар	80.0	48.7	(31.3)	61%
Бусад татвар, төлбөр, хураамж	59.0	116.7	57.7	198%
Бусад нийтлэг төлбөр, хураамж	10.5	5.1	(5.4)	48%
Улсын тэмдэгтийн хураамж	1.5	0.8	(0.7)	56%
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	5.0	3.0	(2.0)	60%
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4.0	1.2	(2.8)	31%
Газрын төлбөр	41.0	40.3	(0.7)	98%
Газрын төлбөр	41.0	40.3	(0.7)	98%
Байгалийн нөөц ашигласны төлбөр	7.5	71.4	63.9	951%
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	-	63.4	63.4	-
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	-	0.5	0.5	-
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	7.5	7.5	0.0	100%
Татварын бус орлого	269.3	6.6	(262.7)	2%
Нийтлэг татварын бус орлого	23.0	6.6	(16.4)	28%
Торгуулийн орлого	5.0	3.8	(1.2)	76%
Төсөв байгууллагын өөрийн орлого	18.0	-	(18.0)	-
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18.0	-	(18.0)	-
Бусад орлого	-	2.7	2.7	-
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	246.3	-	(246.3)	-
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	246.3	-	(246.3)	-
Төсвийн орлого	259.3	318.2	58.9	123%

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын /Төсвийн төвлөрүүлэн захирагч/ 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой ХХОАТ 107.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, 27.2 сая төгрөгөөр давсан байна.

Арилжааны банкин дахь иргэдийн мөнгөн хадгаламжийн хэмжээ буурсантай холбоотой хөрөнгийн орлого 8.5 сая төгрөгөөр тасарчээ.

Малын тоо толгойд ногдуулах албан татварыг 80.0 сая төгрөгөөр төвлөж, гүйцэтгэлээр 48.7 сая төгрөг төвлөрч, 31.3 сая төгрөгөөр тасарсан байна.

Газрын төлбөрт 40.3 сая төгрөг, 6 хадлангийн ургамал ашигласны төлбөрт 7.5 сая төгрөг төлөвлөсөн бөгөөд 2 шонхор шувууны 63.4 сая төгрөг, ус ашигласны 0.5 сая төгрөгийн төлөвлөгдөөгүй орлого төвлөрч, орлогын төлөвлөгөө давуулан биелүүлэхэд нөлөөлжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Асгат сумын Засаг даргын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг татварын болон татварын бус орлогоос 259.3 сая, улсын төсвөөс 545.3 сая, үйл ажиллагааны орлогоос 18.0 сая, урьд оны үлдэгдлээс 251.1 сая, орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгээс 246.3 сая нийт зарлагыг 1,320.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Засаг даргын хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан 1,320.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 800.4 сая төгрөгийг урсгал зардалд, 414.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 79.0 сая төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангаас олгох зээлд, тэтгэвэр тэтгэмж, урамшуулалд 26.4 сая төгрөг зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 898.9 сая төгрөг, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 249.5 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 13.8 сая нийт 1,116.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,156.8 сая төгрөг буюу 87.6 хувьтай байгаа нь харилцах дансны үлдэгдлийг төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 11. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа	800.4	731.8	68.6	91%
2	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6.0	6.0	-	100%
3	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12.5	12.5	-	100%
4	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7.9	7.9	-	100%
5	Дотоод эх үүсвэрээр хөрөнгө бэлтгэх	414.2	338.6	78.6	82%
6	Эргэж төлөгдөх зээл	79.0	60.0	19.0	76%
	Нийт дүн	1,320.0	1,156.8	163.2	88%

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын /Төсвийн төвлөрүүлэн захирагч/ 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсвийн Ерөнхийлөн захирагчийн хөтөлбөр арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал:

Хүснэгт 12. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээ /байгууллага нэг бүрээр/	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Иргэдийн төлөөлөгчдийн хурал					
1	Үндсэн үйл ажиллагаа	89.5	80.9	8.6	90%
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	4.0	4.0	-	100%
Дүн		93.5	84.9	8.6	91%
Засаг даргын тамгийн газар					
1	Үндсэн үйл ажиллагаа	510.0	463.4	(46.6)	91%
2	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6.0	6.0	-	100%
3	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12.5	12.5	-	100%
4	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3.9	3.9	-	100%
Дүн		532.4	485.8	(46.6)	91%
Эмнэлэг					
1	Үндсэн үйл ажиллагаа	24.2	24.2	-	100%
Дүн		24.2	24.2	-	100%
Ерөнхий боловсролын сургууль					
1	Үндсэн үйл ажиллагаа	83.9	83.9	-	100%
Дүн		83.9	83.9	-	100%
Сургуулийн өмнөх боловсрол					
1	Үндсэн үйл ажиллагаа	50.8	50.8	-	100%
Дүн		50.8	50.8	-	100%
Соёл урлаг					
1	Үндсэн үйл ажиллагаа	41.0	28.5	(12.5)	69%
Дүн		41.0	28.5	(12.5)	69%
Орон нутгийн хөгжлийн сан					
1	Хөрөнгийн санхүүжилт	414.2	338.6	75.6	82%
Дүн		414.2	338.6	75.6	82%
Сум хөгжүүлэх сан					
1	Үндсэн үйл ажиллагаа	1.0	0.1	(0.9)	10%
2	Сум хөгжүүлэх сангийн зээл	79.0	60.0	(19.0)	76%
Дүн		80.0	60.1	(19.9)	75%
Нийт дүн		1,320.0	1,156.8	(163.2)	90%

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын /Төсвийн төвлөрүүлэн захирагч/ 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 9.6 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 25.8 сая төгрөг нийт 35.4 сая төгрөг байна.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 23.0 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 8.7 сая, хангамж, бараа материалын зардалд 2.4 сая, урсгал засварын зардалд 0.5 сая төгрөг зарцуулсан ба орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг 0.8 сая төгрөг

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг Даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Миндүг аудит ХХК–ны аудитор Б.Бүзмаа гүйцэтгэж, туслах аудитор Ш.Ундрах, чанарын хяналтыг аудитор С.Энхтөр, хяналтыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг Дарга нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Миндүг аудит ХХК–д 2023 оны 01 дүгээр сарын 25 -ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов..

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 1.5 хувиар буюу 25.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 17.6 сая төгрөгөөр тогтоосон. Төлөвлөлтийн үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹, 15.2.3²-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд 16.8-20.3 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Дээрх зардлууд өмнөх оноос өссөн учир шалтгааныг авч үзвэл:

- Гэрэл цахилгаан, халаалтын зардал өмнөх оноос нэмэгдсэнийг байгууллага тус бүрээр харуулбал: Соёлын төв 4.3 сая, ЗДТГазар 6.0 сая, сургууль 8.3 сая, цэцэрлэг 2.3 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Эдгээр зардлын өсөлт нь өвөл урьд жилээс хүйтэрсэн, тээврийн үнэ өссөнөөс шалтгаалан нүүрсний үнэ нэмэгдсэн, өмнөх жил цар тахалтай холбоотой цахимаар ажиллаж тухайн зардал бага гарсантай холбоотой байна.
- Бараа материалын зардал: Хангамж бараа материалын зардал 4.9 сая төгрөгөөр нийтдээ буурсан боловч, Орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгөөр тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд хайлаас мод худалдан авч зарцуулсан нь бараа материалын зардал өмнөх оноос 16.8 сая төгрөгөөр нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Шилэн дансны цахим системд тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллээс хугацаа хоцроож мэдээлсэн 2 байгууллага байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах зөвлөмж хүргүүлсэн.

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

² сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг Даргын нь бусад хууль тогтоомжийн хүрээнд асуудалгүй байна.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын санхүүгийн гэтгэсэн тайланд 2022 онд завсрын аудит хийгээгүй.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлт сайн.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	-	3	-	100
Нийт дүн	3	-	3	-	100

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орон нутаг болон хоршоо хөгжүүлэх сангаар олгогдсон зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллах, шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн оруулах, байгууллага бүрийн өөрийн онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг боловсруулсан байдлыг аудитад хамруулах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Баяндэлгэр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа төсвийн 7 байгууллага /Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар/, ОНӨҮГ 1 байгууллага, тусгай сангийн 2 байгууллагын нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэсэн.

Эдгээр байгууллагуудад аудитаар нийт 42.7 сая төгрөгийн алдаа³ илэрснээс аудитын явцад 3.8 сая төгрөгийн алдааг залруулж, 4.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 36.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1.7 сая төгрөгийн зөрчилд алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Үүнд: Цалингийн зардлаас 3.8 сая төгрөгийн ХХОАТ-ийг илүү илэрхийлж, татварын өглөг үүсгэсэн алдааг залруулсан байна.

³ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Асгат сумын Засаг Даргын 2022 оны нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 36.6 сая төгрөгийн алдаа, зөрчил⁴ илэрснээс, 36.6 сая төгрөгийн татварын орлого төвлөрүүлэх чиглэлээр зөвлөмж өгсөн байна.

5.1 Зөвлөмж

5.1 Төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой:

5.1.1 Илрүүлэлт:

Малын тоо толгойн албан татвар 14.9 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 /Албан татвар төлөгчийн өмчилж буй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулна/, 5.2 /Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно./, 6 дугаар зүйлийн 6.2 /Албан татварын хэмжээг энэ хуулийн 6.1-д заасан хязгаарт багтаан сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал малын төрөл тус бүрээр тогтооно/, 7 дугаар зүйлийн 7.1 /Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө/, **Төсвийн тухай хуулийн 41 дугаар зүйлийн 41.2.1 /хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх/, тус тус зөрчсөн байна.**

5.1.2 Эрсдэл:

Төсвийн орлого дутуу төвлөрөх, энэ нөлөөллөөр хөтөлбөр арга хэмжээ тасрах

5.1.3 Өгсөн зөвлөмж:

Малын тоо толгойн албан татварыг төвлөрүүлэх чиглэлээр Багийн засаг дарга, татварын байцаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тодорхой арга хэмжээ болгон тусгаж, биелэлтийг хангуулах, мөн уг албан татвараар төвлөрсөн хөрөнгийг буцаан малчдад үйлчилгээ үзүүлэх тохиолдолд татвар төлсөн байдлыг шалгуур үзүүлэлт болгон авч үзэхийг зөвлөж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

⁴ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Хүснэгт № 13 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Албан байгууллага	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг даргын тамгын газар	1	19.4	1	1.4	1	18.0		
Асгат цэцэрлэг	1	1.7					1	1.7
Асгат эмнэлэг	1	2.1	1	2.1				
Сум хөгжүүлэх сан	1	18.6			1	18.6		
Улаан дэл ОНӨҮГ	1	0.1	1	0.1				
Орон нутгийн хөгжлийн сан	1	0.9	1	0.9				
Дүн	5	42.8	3	4.5	2	36.6	1	1.7

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн данс хугацаа хоцроож мэдээлсэн	2						2	
Дүн	2						2	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Хөрөнгийн албан татварын орлого дутуу бүрдүүлсэн							1	33.1
Хог хаягдлын хураамжийн орлого дутуу төвлөрүүлсэн							1	2.8
Газрын татварын орлого дутуу бүрдүүлсэн							1	0.7
Нийт дүн							3	36.6